

# Судалгааны Тойм

№6 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ ХҮНИЙ ЭРХЭД НИЙЦСЭН БАЙДАЛ

### ТОВЧ ТАЙЛБАР

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (ЦБҮАЖ) хүний эрхэд нийцсэн байх нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, цагдаагийн ажил, үйлчилгээг хуулийн хүрээнд, олон нийтэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, алба хаагчийн үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэл хууль ёсны, ил тод байх, мэргэжлийн ур чадвар дээшлэх, мөн тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Тиймээс ННФ-ын захиалгаар судлаачид “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам хүний эрхэд нийцсэн байдал” сэдвийн хүрээнд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон билээ.

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

ЦБҮАЖ хүний эрхэд нийцсэн эсэх дүн шинжилгээг хийхдээ өргөнөөр хэрэглэгддэг тоон болон чанарын судалгааны арга зүйг хослуулсан ба энэ хүрээнд онол, эрх зүйн зохицуулалт, гадаад, дотоодын судлаачдын бүтээл, судалгааг харьцуулан судалж, хууль тогтоомж, үйл ажиллагааны журамд тодорхой шалгуур үзүүлэлтээр дүн шинжилгээ хийж, үр дүнгээ магадлан шалгахын тулд

### СУДАЛГААНЫ ДҮН

2008 оноос ЦБ үйл ажиллагаагаа зохицуулсан эрх зүйн актуудыг ОУ-ын жишигт нийцүүлэн шинэчлэн системчлэх ажлыг эхлүүлсэн. Үйл ажиллагааны журмуудыг кодчилж, эмхэтгэж хэвлээд эдүгээ 4 дэх удаагаа шинэчлээд байна. Мөн нэгж журам

ЦБ-ын үйл ажиллагаанд баримтлах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 9 бүлэг, 258 кодчилсон журам (ЦБҮАЖ)-аас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, хөндөж болзошгүй гэж үзсэн 132 журмыг сонгон авч судаллаа. ЦБҮАЖ хүний эрхэд нийцсэн байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг гаргахдаа ЦБ-ын үйл ажиллагааны явцад хөндөгдөж болзошгүй эрхийг сонгон авав.

Энэхүү тоймоор судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорьсон ба судалгааг [www.forum.mn](http://www.forum.mn) сайтаас үзнэ үү.

экспертүүд болон төрөл бүрийн түвшний албан хаагчтай уулзаж ярилцахдаа фокус ярилцлагын аргыг тус тус ашиглалаа. ЦБҮАЖ хүний эрхэд нийцсэн эсэхийг шинжлэхдээ НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газраас гаргасан “Хүний эрхийн индикаторууд”<sup>1</sup> гарын авлагын хүрээнд аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулав.

шинэчлэгдэх бүрт ЦБ-ын дотоод сүлжээгээр түгээж, цаг алдалгүй мөрдөж ажиллах боломжийг хангаж иржээ. Энэ хугацаанд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон

<sup>1</sup> The Office of the United Nations High Commissioner for Human Rights, Human Rights Indicators, 2012, [https://www.ohchr.org/Documents/Publications/Human\\_rights\\_indicators\\_en.pdf](https://www.ohchr.org/Documents/Publications/Human_rights_indicators_en.pdf)

Цагдаагийн албаны тухай хуулиудыг шинэчлэн баталсантай холбогдуулан зохих өөрчлөлтийг ЦБҮАЖ-д тухай бүр тусгаж явжээ.

ЦБ-ын үйл ажиллагааны нийт 258 журмаас 60 гаруй хувьд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах заалтыг тусгажээ. Тухайлбал зарим хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх (код 109), Цагдаагийн алба хаагчийн шинэ санал, санаачилгыг дэмжих (код 116), Шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа (код 200), Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх (код 215) гэх мэт. Судалгааны ажлын хүрээнд сонгож авсан 132 журмыг дараах байдлаар ангилан судаллаа. Үүнд:

- хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжид нийцсэн;
- хүний эрхийн хэм хэмжээ, хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа;
- хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцээгүй;
- дотогшоо чиглэсэн.

Дүн шинжилгээ хийсэн 132 журмаас 45-ыг цаашид хэвийн мөрдөж, үлдсэн 87 журамд ямар нэг нэмэлт, өөрчлөлт оруулах эсвэл бүхэлд нь шинээр боловсруулах хэрэгцээ шаардлага байна. Эдгээрээс хүний эрхийг хамгаалахаар тухайлан боловсруулсан 3, хүний эрхийн талаар тухайлан заасан 46 журам байна. Мөн 14 журмын үйлчлэл дотогшоо чиглэсэн

## ЗӨВЛӨМЖ

- Цагдаагийн төв байгууллагаас үйл ажиллагаандаа зориулсан “хүний эрхийн стандартыг хэрэгжүүлэх цогц бодлого”-ыг батлах, уг бодлогыг хэрэгжүүлэх талаар ЦБҮАЖ-д тусгах.
- Цагдаагийн алба хаагчид ОУ-ын хүний эрхийн хэм хэмжээг сайтар мэдэх, хэрэглэх үүрэгтэй. Тиймээс ЦБ-д хүний эрхийн зөрчил гаргуулахгүй байх, алба хаагчдын хүний эрхийн сэтгэлгээг хөгжүүлэх, албаны нэр хүндийг дээшлүүлэхийн тулд анх ажилд орохоос нь эхлэн давтамжтайгаар сургалтад заавал хамруулах талаар журамд тусгах.
- Цагдаагийн алба хаагч хүний эрхийг хангаж ажиллахын тулд зарим тодорхой үйл ажиллагааны үед тухайлан зориулсан зөвлөмжийг журамд тусгаж өгөх.

хэдий ч цагдаагийн алба хаагч үйл ажиллагаагаа хүний эрхэд нийцүүлэн явуулахад тодорхой хэмжээнд нөлөөлөх тул дүн шинжилгээ хийлээ.

Хууль тогтоомж, хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцүүлэх шаардлагатай 87 журамд дараах нийтлэг зөрчил байна. Үүнд, хууль тогтоомжид байхгүй нэр томъёо хэрэглэсэн, хууль тогтоомжийг хуулбарлан давтсан, найруулгын хувьд ойлгомжгүй, журмын зорилгоо бүрэн хангаагүй буюу цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалахад зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой журамлаагүй, хэт ерөнхий байдлаар боловсруулсан зэрэг болно.

Тиймээс ЦБҮАЖ нь холбогдох ОУ-ын гэрээ, конвенц, хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан, хууль тогтоомж шинэчлэгдэх бүрт тэдгээрт нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн ч цаашид хүний эрхийг хангах чиглэлээрх ОУ-ын баримт бичиг, стандартад нийцүүлэн улам боловсронгуй болгоход анхаарах нь зүйтэй. Мөн тодорхой ажиллагааны үед цагдаагийн алба хаагч аюулгүй байдлаа хэрхэн ханган ажиллах, аюултай нөхцөл байдалд орсон үед хэрхэх (ялангуяа ганцаар ажиллаж байгаа, алслагдмал газарт байхад гэх мэт) талаарх зохицуулалтууд хомс байгааг анхаарч нарийвчлан зохицуулах шаардлагатай.

- ЦБҮАЖ боловсруулах (нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр журам гаргах, хүчингүй болгох, найруулга зүйг засварлах) ажилд ЦБ, алба хаагчдаас тоймтой санал гаргахгүй байх, бусад мэргэжлийнхний саналыг авах, судалгаа дүгнэлт гарган ашиглах ажил дутмаг зэргээс ЦЕГ-ын Хуулийн хэлтэс, алба хаагчид голлон ажиллаж ирсэн практикийг халж, асуудалд шинжлэх ухаанч байр сууринаас хандах, аль болох олон талын оролцоог хангах, шийдвэрийн нөлөөллийг урьдчилан судлах, үүнд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг тусгайлан тусгаж өгөх нь зүйтэй.
- Судалгааны хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинээр боловсруулах шаардлагатай гэж дүгнэсэн 87 журмыг нэн даруй шинэчлэх ажлыг эхлүүлэх.

### СУДЛААЧИД:

Д.ЭРДЭНЭБААТАР, Доктор (Ph.D)

Ю.БАДАМХАНД, Доктор (Ph.D), Дэд профессор

Д.БУЛГАН, Доктор (Ph.D)

### СУДАЛГААНЫ ТОЙМЫГ БОЛОВСРУУЛСАН:

Д.БУЛГАН, Доктор (Ph.D)

### САНАЛ, ШҮҮМЖ ӨГСӨН:

Б.Хишигсайхан, ННФ-ын Хуулийн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамьян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: (976) 76113207

<http://www.forum.mn>  
<http://www.twitter.com/ForumOS>

<http://facebook/OpenSocietyForum>  
[http://www.instagram.com/open\\_society\\_forum](http://www.instagram.com/open_society_forum)